

22-Р БААЗ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХЭЛЭЛЦСЭН НЬ

“22-р Бааз ХК”-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит бус хурал 2024.12.23-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 39-р хороо өөрийн байранд эхлэв.

Хуралд хувьцаа эзэмшигчдээс:

- “Монгол Секюритиес ҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар/ТУЗ-ийн дарга/
- Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Б.Номин 268,622 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэгдсэн төлөөлөгч/
- З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- “Чингис Хаан Сек” ХХК 56,870 ширхэг хувьцааны саналаар /Үүсгэн байгуулагч, захирал/
- Б.Ганболд 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- С.Пүрэвжав 710 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

2,214,383 ширхэг хувьцаа буюу 83,52 хувийг эзэмшигчид хуралд оролцов.

ТУЗ-ийн гишүүдээс:

- Л.Гүндэгмаа
- Т.Зоригтбаатар
- З.Номундарь
- П.Эрдэнэчулуун
- Т.Эрдэнэбаатар
- Б.Баярсайхан
- А.Баатаржав
- Ю.Туяацэцэг
- Ц.Энхтуяа

Оролцов.

Мөн хуралд:

- “22-р Бааз” ХК-ийн захирал Т.Зоригтбаатар
- 22-р Бааз ХК-ийн менежер Д.Солонго
- Тооллогын комиссын дарга Б.Мөнгэрэл
- Тооллогын комиссын гишүүн М.Нэргүй
- Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Эрдэнэбаяр
- Хурлын нарийн бичиг З.Туул

нар оролцов.

Хурлыг хурал даргалагч ТУЗ-ын дарга Л.Гүндэгмаа нээж үг хэлэв:

- Сайн байцгаана уу? Тооллогын комисс хүмүүсээ бүртгэж дууссан бол хурлаа эхэлье.

Тооллогын комисс ирц танилцуулав.

Л.Гүндэгмаа:

- Манай дийлэнх хувьцаа эзэмшигч маань ирж хурлын ирц бүрдсэн тул хурал эхэллээ. 2024 оны ээлжит бус хурал 2024.11.29-нд товлөгдсөн боловч ирц хүрээгүйн улмаас хойшлогдож хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон компанийн тухай хуульд заасны дагуу өнөөдрөөр товлोज хуралдаж байна. Хурлаар бид нар ганцхан асуудал хэлэлцэхээр санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн биржд хүргүүлсэн. Энэ асуудал нь “Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх газар болон үл хөдлөх эд хөрөнгө худалдахтай холбоотой их хэмжээний хэлцэл байгуулахыг дэмжих асуудлаар зөвшөөрөл олгох, их хэмжээний гэрээ байгуулах эрх олгох тухай” асуудал байгаа. Бид нар хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 12 дугаар сарын 19-ний өдрөөр тасалбар болгож бүртгэсэн. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөн зар өгсөн. Тэгэхээр асуудлаа хэлэлцье. Санал байвал хувьцаа эзэмшигчид маань илэрхийлээрэй. Хувьцаа эзэмшигчдийн өмнөх хурал дээр ерөнхийдөө яриад үүн дээр санал аваагүй, дараа нь бидэнд шаардлага гараад ТУЗ-ийн хурлаар шийдвэр гаргаад холбогдох байгууллагууддаа бичиг баримтуудаа явуулж зараа гарган хуулийн дагуу дахин хурлаа зарласан байгаа. Газар болон үл хөдлөх эд хөрөнгийг худалдахтай холбоотой их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох асуудал дээр та бүхэн минь саналаа хэлээрэй.

3.Номундарь:

- 22-р Бааз ХК-ийн нийт талбайн хэмжээ 6,3 га байдаг. Компанийн үйл ажиллагаа, санхүүжилтийг үр ашигтай ажиллуулахаар нь тодорхой хэсэг талбай, үл хөдлөхөө зах зээлийн үнэлгээ тогтоож тохирон худалдаж, тодорхой санхүүжилтийг шийдэн компанийн үйл ажиллагааг үр ашигтай цааш нь явуулах шаардлагатай гэж үзэн миний зүгээс энэ саналыг дэмжиж байна. Хувьцаа эзэмшигчид болон, ТУЗ-ийн гишүүд маань асуух асуулт байвал компанийн зүгээс шаардлагатай мэдээллийг өгнө. Ер нь компани жил болгон өөрсдийн тайлан төлөвлөгөөг танилцуулаад, нийт хувьцаа эзэмшигчдийн хурлаараа танилцуулаад яваад ирсэн байгаа. Энэ удаад бол компанийн санхүүжилтийг идэвхтэй үр ашигтай ажиллуулахад хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэх шаардлагатай байгаагаас газар үл хөдлөх хөрөнгөө худалдах асуудлыг оруулсан. Цаашлаад санхүүжилтийн төлөвлөгөө зэрэг нарийн асуудлуудаа шийдэхийн тулд эхлээд хувьцаа эзэмшигчдээсээ үл хөдлөх болон газраа үнэлээд худалдах асуудал дээр санал авахаар хуралдаж байна.

С.Пүрэвжав:

- Сайн байна уу. Асуулт асууж болох уу. Хувьцаа эзэмшигч Пүрэвжав байна. Энэ хэр их хэмжээний газар хэр их хэмжээний үл хөдлөх худалдах санал яригдаж байгаа юм бол?

З.Номундарь:

- Ерөнхийдөө 6,3 га газар байгаагаас үл хөдлөх газрын үнэлгээний хууль гэж байгаа тэр хуулиар газар нь 8,9 тэрбум гэсэн үнэлгээтэй, тэгээд үл хөдлөх хөрөнгөө үнэлнэ, газрынх нь хэмжээгээр хуваарилж үнэлэх үү, яаж үнэлэх үү гэдгийг зах зээлийн хамгийн боломжтой үнэлгээгээр худалдах саналтай байгаа гэж ойлгож болно.

Л.Гүндэгмаа:

- Би энэ хувьцаат компанийн захирлаар 2003 оноос эхлэн ажиллаж байгаа. Эхний үед бид нар тодорхой хэмжээний ачааны машинтай, тээврийн бааз байсан. Зах зээлд шилжсэн ачаа бараа тээвэрлэлт ховор болоод 2003-2008 он хүртэл алдаг оног явсаар ихэнх хүмүүс нь машинуудаа хувьдаа авсан. 2008 оноос машинуудын эдэлгээ дууссан. Ер нь ТУЗ-ийн даргынхаа хувьд, компанийнхаа захиргааны хувьд томоохон газартайн хувьд байшин барилга баръя гэж хэлэлцэж байсан. Манай компанийн байгаа барилгууд олон жилийн насжилттай, ажил үйлчилгээ явуулахад шаардлага хангахгүй. 2012 онд бид нар ерөнхий төлөвлөгөө хийлгээд, үнэлгээ хийлгэсэн. Тэр үед манайхыг дулаанаар хангах боломжгүйн улмаас ажил төлөвлөгөө хойшилсон. Амгалан цахилгаан станц ашиглалтад ороход эрх олгоно гэж байсан. Амгалан цахилгаан станц ашиглалтад орсны дараа бид нар ерөнхий төлөвлөгөө ярилцсаар байсан. 2012 оныг бодвол үнэлгээ их өссөн. Яг бэлэн хөрөнгө оруулагч бидэнд олдохгүй байсан. Манайд нэг японы хөрөнгө оруулагч байсан. Тэр хөрөнгө оруулагч маань компани чинь ашиггүй ажиллаж байна гэсэн. Бид нар энэ хэдэн хуучин байшингаа түрээслэхийг нь түрээслээд, заримдаа түрээслэгч олдохгүй ч үе байсан. 2015 оноос хойш төлөвлөгөө хийлгээд явж л байгаа 2020-д он хүртэл. Яг хөрөнгө оруулагч олдохгүй байсан. Нэлээдгүй компанитай ярилцаж уулзсан, амжилттай болоогүй. Ийм байдлаар ингэж удаан байснаас тодорхой хэмжээний том газар бид нар байшин барилга барьж чадахгүйгээс хойш хөрөнгө оруулаад бүтээн байгуулалт хийх компанид газраа хэсэгчлэн худалдаж борлуулъя гэсэн саналтай байгаа. Тэгж байж хөрөнгө босгож цаашдаа явахаас биш энэ маягаараа байвал газар бол бид нар яг өмчилсөн биш эзэмшигч байдлаар ашиглаж байгаа болохоор энэ газрыг ямар нэгэн байдлаар улс төрийн байдал янз бүр байгаа болохоор газрыг маань хагаслах эсвэл улсын зориулалтаар гээд авахыг ч үгүйсгэхийн аргагүй болж байна. Дээр нь манайх Улаанбаатар хотын А зэрэглэлийн байршилд. Иймээс зөвлөлдөж ярилцсаны үндсэн дээр ингэх нь зөв юм байна гэсэн саналд хүрээд байна. Бид нар гаднын олон компаниудтай уулзаж ярилцаж үзсэн. Хятад компаниудын орж ирэх асуудал хүндрэлтэй байсан. Дараа нь найдвартай компаниудынхаа нэгэнд худалдъя гэсэн саналтай байгаа. Тиймээс энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдээрээ хэлэлцэж шийдэхээр хуралдаж байна. Бид нар ч мөн оролцоно ТУЗ-ийн хувьд. Та бүхэн саналаа хэлээрэй.

Б.Ганболд:

- Асуулт асууя. 6,3 га бүгдийг нь зарах гэж байгаа юм уу? Зарим хэсгийг нь зарах гэж байгаа юм уу?

3.Номундарь:

- 2 хувилбар яригдаж байгаа. Хэсэгчилж болон бүтнээр нь шилжүүлэх.

Б.Ганболд:

- Бүтнээр зарлаа гэж бодоход дараа нь үйл ажиллагаа нь хаана явагдах вэ? Зарсан хөрөнгийн зарцуулалтаар юу хийх гэж байгаа вэ? Гэдэг асуудал байна. Одоогоор миний ойлгож байгаагаар түрээсээр л яваад байх шиг байна. Тэгэхээр зарах гэж байгаа бол төлөвлөгөө байгаа байх, төлөвлөгөө нь ямар төлөвлөгөө байгаа вэ? Юунд зарцуулах гэж байгаа вэ? Гэж асуумаар байна. Эцсийн байдлаараа бүрэн зарах юм уу эсвэл хэсэгчлэн зарна гэдэг шийдвэр энэ хурлаас гарах юм уу эсвэл хэсэгчилж юм уу бүрэн зарахад ТУЗ-д эрх өгөх гээд байгаа юм уу? Шийдвэрийн төсөл маань яг нарийн тусах хэрэгтэй юм шиг байх юм.

Б.Эрдэнэбаяр:

- Хувьцаат компанид хуулийн зөвлөгөө үзүүлэх эрхтэй “Инсто Лекс” хуулийн фирмийн өмгөөлөгч Эрдэнэбаяр байна. Ямар асуудлаар өнөөдрийн ээлжит бус хурлыг хийж байгаа вэ гэхээр компанийн үйл ажиллагаа санхүүжилт багатайн улмаас, мөн дээрээс нь энэ их хэмжээний газрыг олон жил ашиглахгүй байгаа нь нэгдүгээрт нийгмийн хариуцлагын хүрээнд хотынхоо өнгө үзэмжийг дээшлүүлэх шаардлага хотын зүгээс тавьдаг, мөн олон нийтийн гарц гаргах асуудал өмнө нь компаниас тодорхой хэмжээний газрыг хүчээр төрөөс буцааж авч байсан тохиолдол байдаг. Иймэрхүү байдлаар явбал хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг ч тэр хуулийн этгээдийн эрх ашиг ч тэр хөндөгдөнө. Дээрээс нь иймэрхүү байдлаар явах юм бол болохгүй нь гэдэг талаас нь харж байгаа. Энэ хурлыг хийж байгаа асуудал нь ТУЗ энэ асуудлаар буюу хөрөнгөө зарж байгаа асуудлаар 100 хувийн ирцтэй хэлэлцэх ёстой. ТУЗ ирц бүрдээгүй учир хувьцаа эзэмшигчдийн хурал дээр шилжүүлбэ гэдэг байдлаар орж ирж байгаа. Өнөөдөр энэ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж энэ асуудлыг хэлэлцэж байгаа. Дэмжих үү? Дэмжихгүй юу, хувьцаа эзэмшигчид ямар санал байр суурьтай байгаа вэ? Тэгэхгүй бол ТУЗ шийдэж чадахгүй юм байна гэдэг байдлаар орж ирж байгаа юм. Бүрхэг байна гэдэг асуудал нь компанийн стратегийн үйл ажиллагааны хувьд ямар байх вэ? Энэ газартайгаа энэ чигээрээ яваад байх уу эсвэл тодорхой хэмжээгээр газрынхаа тодорхой хувийг холбогдох сонирхогч этгээдэд борлуулах, дан ганц газар биш үл хөдлөх хөрөнгө дээр нь байгаа тэрийг тодорхой хувиар борлуулах байдлаар санхүүжилтээ босгох байдал байж болно. Энэ асуудлыг хэлэлцээд шийдвэрээ гаргачихвал дараа дараагийн асуудлыг ТУЗ шийдвэрлээд явахад харьцангуй амар юм гэж харж байгаа. Компанийн зүгээс урьдчилан харж төлөвлөж байгаа байдал нь юу гэхээр хэсэгчлээд тодорхой хэмжээний газрыг гуравдагч этгээдэд зах зээлийн үнээр нь үл хөдлөх хөрөнгийн хамт зарна, борлуулна. Үлдэгдэл газар нь компани дээрээ үлдэнэ. Тэр нь үлдэж болно цааш нь хангалттай зах зээлийн үнэ санал болгосон худалдан авагчид шилжүүлэх боломж нь байгаа. Бага хэмжээний хувьцаа эзэмшигчид үүн дээр

өөрсдийнхөө саналыг гаргаж болно. Гэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурал дээр өөрийнх нь эрх ашгийн эсрэг санал гарах юм бол компанид хувьцаагаа буцааж зарах эрх нь байгаа. Иймэрхүү л саналыг олонх хувьцаа эзэмшигчдийн зүгээс гаргаж байгаа. Олонхынхоо саналаар асуудал шийдэгдээд явах байх. Хурлын ирц 50+1 хувь учраас хурлын ирц хүрсэн гэдгийг сая хурал даргалагч хэллээ. Тухайн хэлэлцэх асуудлаар үүн дээр бид нар яг тэр компанитай байгуулах гэж байгаа гэдэг гэрээ хэлцэл байхгүй. Ерөнхийд нь ерөнхий шийдвэрээ гаргаад явна. Дараа нь явцын дунд ТУЗ дээрээ үүрэг өгөөд ТУЗ түүний дагуу яг хэн гэдэг этгээд ямар үнийн санал өгөөд тэр нь хувьцаа эзэмшигчдийн өгсөн чиглэл буюу компанийн эрх ашигт нийцэж байна гэвэл түүнтэй гэрээ байгуулах гэрээний нөхцөлийг тусгайлан байгуулаад явах асуудал байгаа. Үүн дээр хэрвээ ямар нэгэн байдлаар сонирхлын зөрчилтэй этгээд байгаа бол оролцохгүй байх нь хууль дээрээ байгаа учир хууль зөрчигдөхгүй байх гэж харж байгаа. Хэрвээ та нар эд хөрөнгө газар дээр сонирхолтой, би гол хувьцаа эзэмшигч биш ч гэсэн би ийм үнээр худалдаж авъя гэх юм бол энэ хурлын дараа дэмжих дэмжихгүй гэдэг шийдвэр гарсны дараа та нар бас саналаа хэлээд, энэ хэсгийг би худалдаж авъя тэдэн төгрөгөөр худалдаж авъя гэсэн үнэ өрсөлдүүлэх боломж байгаа. Та нар мэдээж хөрөнгөн дээр сонирхолтойгоор орж байгаа гэж би харж байна. Тиймээс эхлээд хувьцаа эзэмшигчдийн хурал дээр энэ асуудлыг дэмжиж байгаа дэмжихгүй байгаа гэсэн шийдвэр гарсны дараа олонх нь яаж шийдсэний дараа та нар бас худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй гэдгийг та бүхэн өөрсдөө мэдэж байгаа байх.

Л.Гүндэгмаа:

- Баазын зүгээс хэлэхэд, одоогийн манай хувьцаа эзэмшигчид маань энэ олон жил дуугай харж явж ирээгүй. Зөндөө ярилцана, зарим нь эхнээсээ өөр хүнд хувьцаагаа зарсан тохиолдол ч бий. Яагаад гэвэл энэ хувьцаа компани гэдэг чинь утгаараа ашигтай ажиллаж байж энэ хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг өгч хөгжиж дэвших байтал, миний хувьд яахав жаахан санаачилга багатай байсан ч тал байгаа. Гэхдээ бүх л зүйл хөрөнгө мөнгөний асуудал дээр тогтдог учраас, би ганцаараа өөрөө юм хийх гэдэг асуудалтай. Дээрээс нь манай том хувьцаа эзэмшигч нар маань байнга л санал тавьдаг компанийг хэрхэн өөрчлөх үү яах уу гэдэг дээр. Өөрсдөө хувьцаагаа оруулсан, мөнгөө оруулсан хүмүүс чинь бид нарт нэмээд мөнгө төгрөг гаргаж өгөөд хийе гэхэд янз бүрийн санхүүгийн асуудлууд байгаа. Бид нар олон жил болсон байшиндаа цөөхөн төгрөгөөр түрээсэлж олсон мөнгөнөөсөө засвар хийгээд энд ажиллаж байгаа хэдэн ажилчдынхаа цалинг тавиад таардаг. Харин сүүлийн 3,4 жил түрээс маань овоо идэвхтэй нэмэгдэх тийшээ явж цалин мөнгөө тавьж байгаа. Ер нь олон жил их яригддаг байсан. Хэрвээ юм хийхгүй бол ийм ийм аргаар ийм үйл ажиллагаа явуулбал яасан юм гэдэг зөндөө олон санал гарч байсан. Заримдаа ч дэмжигдэхгүй, тухайн үеийн цаг үеийн байдлаас шалтгаалаад хойшлогдоод байсан. Сая 2024 оноос эхлээд нэлээн хүчтэй яригдаад, ерөөсөө асуудлаа шийдье гээд ийм шийдвэрт хүрсэн байгаа. Сая өмгөөлөгчийн хэлснээр та бүхэнд өөр асуулт санал юу байна, чөлөөтэй. Протокол бичигдэж байгаа. Саналаа хэлээрэй.

А.Баатаржав:

- Санал хэлэх хүн байхгүй бол, асуулт байхгүй бол шууд санал хураалтаа явуулаад шийдвэрээ гаргаад дэмжих дэмжихгүйгээ харцгаая.

Л.Гүндэгмаа:

- Тийм тэгье. Тэртээ тэргүй хувьцаа эзэмшиж байгаа хүмүүс нь байгаа. Нэмж санал хэлэх хүн байна уу?

Б.Ганболд:

- Гол асуудал нь хэдий хэмжээний газрыг хэдий хэмжээний үл хөдлөхтэй борлуулах гэж байна вэ гэдгийг мэдмээр байна.

Л.Гүндэгмаа:

- Бид нар одоо шийдвэр гарч байж шийдэхгүй бол болохгүй.

З.Номундарь:

- Газрын тухай хууль дээр яг энэ А бүсэд байгаа газрын суурь үнэлгээ гэж байгаа үүгээр 8,9 тэрбум байсан. Бид нар мэдээж түүнээс илүү байх гэж бодож байгаа. Нийт 6,3 га байгаа эхний санал болгож байгаагаар 4,9 га-гаа түрүүлж борлуулах тэгээд үлдсэн га дээрээ бүтээн байгуулалт хийх тийм шат дараалалтай л

Л.Гүндэгмаа:

- За өөр саналтай хүн байна уу?

Б.Ганболд:

- Тэр зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг яг авч чадсангүй. Компани хөрөнгөө зарж үрж болно л доо асуудал байхгүй. Дараа нь зарцуулалт нь яах вэ, ямар төлөвлөгөөгөөр юу хийх гэж байгаа вэ гэдэг талаараа л мэдмээр байна.

Л.Гүндэгмаа:

- Зарвал бид нар төлөвлөгөө гаргана. Энэ хэмжээний мөнгөнд юу хийж болох уу, тэгэхгүй бол зараагүй байж баахан төлөвлөгөө хийгээд яаж гарах нь мэдэгдэхгүй. Тэгээд угаасаа зарцуулалт нь тодорхой л явна. Санхүүгийн тайлантайгаа явна. Ямар ч байсан хөрөнгө оруулалтаа шийдэж байна гэсэн ойлголт авах хэрэгтэй.

Б.Ганболд:

- 4,9 га гэдэг чинь нэлээн том га яригдаж байна. Үнэлгээ бол суурин үнэлгээнээс илт давуу өндөр байгаа. Энүүхэн энд л гэхэд

Л.Гүндэгмаа:

- Мэдээж тэрийг бодолцоно.

З.Номундарь:

- Өнөөдөр яг Монголын нөхцөл байдал бол тодорхой хэмжээнд газрын нэг дор их хэмжээгээр төлөхүйц тийм компани тийм олон биш байгаа. Бид нар хамгийн сайн хувилбараар л зах зээлийн үнэд хүргэнэ л гэж бодож байна.

Л.Гүндэгмаа:

- Газрын үнэлгээ өссөн учраас бид нар тэрэнд дарагдаад байгаа. Жилд далан хэдэн сая төгрөг төлнө. Бас л чардайж байж төлж байгаа. Газраа байлгаж байхын төлөө. Төлбөр төлөхгүй хэдэн сар болоход шууд хураагдана. Тиймээс бид нар орлого багатай ч гэсэн яаж ийж байгаад газрынхаа төлбөрийг төлдөг. Өнөөдөр яг ингээд л яваад байх нь зөв юм ууг үгүй бол яах уу, санал өгсөн компани байгаа, бид нар асуудлаа шийдэж байж тэр улсуудтай гэрээ хийнэ. Аль болохоор л компани үр ашигтай л үлдэнэ, тэрнээс ямар ч үр ашиггүй байна гэж байхгүй.

Б.Баярсайхан:

- Би нэг юм хэлчих үү? Энэ хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх авах гэж зохион байгуулж байна гэж ойлгож байгаа. Мэдээж бид нар хөрөнгө оруулагч талтай төсөл хөтөлбөр ярихаар бол хувьцаа эзэмшигчдийн хурлаасаа зөвшөөрлөө аваагүй бол тэнд бас асуудал үүснэ. Тиймээс эхний ээлжинд бид нар зөвшөөрлөө авч байна, та нараас, хувьцаа эзэмшигчдийн хурлаараа. Тэр үндсэн дээрээ бид нар цаашлаад гэрээ хэлцэл төслөө ярих үндэслэл болж байгаа нэгт. Хоёрт гэвэл мэдээж өмч хувьчлал явагдсанаас хойш ногдол ашиг тараах боломж хүнд байсан. Энэ газар дээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байж тэр маань өөрөө үр ашигаа өгч байж нийт хувьцаа эзэмшигчдэд эзэмшиж байгаа хувьцааных нь дагуу ашиг хүртэх энэ боломжийг төсөл хэрэгжүүлж байж л олгох гаргалгаа байгаа. Боломж гэх юм уу даа. Тэгж л ойлгож байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаасаа эрх өгөөд ТУЗ-руу, ТУЗ-аас цаашаа гэрээ хэлцэл хийгдээд төсөл хөтөлбөр боловсруулагдаад явах байх, үндэслэл шат дараалал нь ийм л гэж ойлгоод байна.

Л.Гүндэгмаа:

- Манай өөр хувьцаа эзэмшигчидээс санал байна уу? Зөвшөөрсөн нь хэд зөвшөөрөөгүй нь хэд гэсэн тоогоо гаргаад явчихна.

Ю.Туяацэцэг

- Одоо ер нь энэ газрыг эргэлтэнд оруулаад ашигласан нь зөв байх.

Б.Ганболд:

- Эргэлтэнд оруулж зарах нь зөв л дөө. Гэхдээ яг бариад ирсэн төсөл байхгүй байнашгэ бидэнд.

Л.Гүндэгмаа:

- Шийдвэрээ гаргаж байж л төслөө

Б.Ганболд:

- Төслөө бид нар бас харах хэрэгтэй байна. Ер нь бол.

З.Номундарь:

- Эхлээд шийдвэрээ гаргачихаад дараа нь

Л.Гүндэгмаа:

- Одоо энэ газар зарж болох уу яах уу гэдэг шийдвэр гарч байж, за тэгвэл бид нар болох юм байна гэвэл бид нар төслөө хийх ёстой, тэгж байж төсөл хэрэгжинэ. Түүнээс одоо бид нар ямар ч зөвшөөрөлгүйгээр төсөл хийгээд

Б.Эрдэнэбаяр:

- Бид нар баахан юм яриад л байдаг, тэдээр зарна гээд л байдаг эсвэл гадны хүмүүстэй яриад л байдаг хувьцаа эзэмшигчдийн хурал дээр шийдвэр гарахгүй бол нөгөө ярьсан хөдөлмөр чинь талаар болно. Тиймээс түүнээсээ өмнө эхлээд ямар ч байсан хувьцаа эзэмшигчдээсээ зөвшөөрлийг нь авчихъя, дараа нь яг боломжтой худалдан авах хүн нь хэн байна, худалдан авагч нь хаа байна хэдээр зарах уу гэдэг юмаа яриад ТУЗ-даа эрхээ олгочихсон ТУЗ нь шийдвэрээ гаргаад явна. Шаардлагатай бол ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэгэнт зөвшөөрлөө авчихсан юм чинь танилцуулах асуудал бол дараагийн асуудал.

Л.Гүндэгмаа:

- Одоо манай том том хувьцаа эзэмшигчид ороод ирчихсэн тэд нар маань өөрсдөө зөвшөөрлөө өгчихвөл шийдэгдээд, бид нар үүнийг өнөөдөр ганцхан яриагүй олон удаа яриад, ер нь яасан дээр вэ, ингэсэн нь дээр үү, тэгээд энэ том хувьцаа эзэмшигчид маань гомдолтой байгаа, маш их хувьцаа эзэмшихээд ямар ч үр ашиг байхгүй олон жил явлаа гээд. Тэгэхэд бидэнд итгэл өгч байгаа юм. ТУЗ шийдээд өг. Та нар хувьцаа эзэмшигчдийн хурлаа хий бид нар оролцье энэ асуудлаа шийдчихээд нэгдсэн бодлого гаргаад яг энэ удирдаж байгаа гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга гишүүд чинь нийлээд төсөлөө хий. Нөгөө сонирхолтой компанитайгаа нэгдэж байгаад за яасан нь дээо вэ? Аль нь ашигтай байна уу? Ийм асуудлыг шийд гэсэн. Одоо тэгэхээр өөр санал байхгүй бол саналаа хураа манай том хувьцаа эзэмшигчид маань эдгээр хүмүүс байна. За тэгэхээр зөвшөөрч байна уу?

Б.Эрдэнэбаяр:

- Дэмжиж байгаа нь гараа өргөөд дэмжихгүй байгаа нь гараа өргөхгүй байж болно.

Б.Ганболд:

- Саналын хуудсаараа явахгүй юм уу?

Л.Гүндэгмаа:

- Саналын хуудас өгсөн байгаа. Түүгээрээ шийдье.

Б.Баярсайхан:

- Саналын хуудас бөглөх нэг анхааруулга хэлье зөвшөөрсөн гэдэг дээр өөрийнхөө эзэмшиж байгаа хувьцааны тоог л тавина.

Л.Гүндэгмаа:

- Зөвшөөрсөн саналын тоо гэдэг дээрээ өөрийнхөө саналын тоог тавиад л болоо. Санал авах хуудасаа л бөглөөд өгчих.

Санал хураалт явагдав.

Л.Гүндэгмаа:

- Би гүйцэтгэх захирлаар 18 жил ажилласан. Сүүлийн 6,7 жил ТУЗ-ын дарга болсон. Надаас компанийн талаар асууж болно. Хүмүүс хуралдаа ирдэггүй. Хэдхээн хувьцаа эзэмшигчид маань л ирдэг. Шинэ хүмүүс өнөөдөр л харж байна. Ер нь манайхан хувьцаа эзэмшиж байгаа хэрнээ хуралдаа ирдэггүй, ирвэл манайх их олон хувьцаа эзэмшигчтэй 100 гаран.

Б.Эрдэнэбаяр:

- Олонхийн саналаараа шийдчихдэг болохоор тэгдэг байх.

Л.Гүндэгмаа:

- Магадгүй гэхдээ хувьцаа эзэмшиж байгаа хүн уул нь компанийн үйл ажиллагааг сонирхож ирмээр л байгаа юм. Хувьцаа нь нилээн төвлөрсөн, хэдэн том хувьцаа эзэмшигчидтэй болохоор тэд нар шийдвэрээ гаргах байх гэдэг байж магадгүй, манай хууль эрхзүй ч ер нь тийм байдаг болохоор.

С.Пүрэвжав:

- Одоо саналаа шууд танилцуулах уу?

Л.Гүндэгмаа:

- Шууд.

З.Номундарь:

- Хурлын хэлэлцэж байгаа асуудал шийдэгдчихвэл мэргэжлийн компаниар төлөвлөлт хийлгээд шаардлагатай бол танилцуулна.

Б.Эрдэнэбаяр:

- Компани дээрээ ирээд мэдээлэл авч болно.

З.Номундарь:

- Бид нар энэ асуудлаа шийдчихвэл маш богино хугацаанд хавараас ч юм уу хурдан хугацаанд А даалгавар авна. Хуучин бол нийтэд нь хийгдсэн төлөвлөлтийн юмнууд байгаа. Гэхдээ тэр маань дулаанаа авч чадахгүй зэргээс шалтгаалаад нилээн удаан гацсан. Одоо бид нар үлдсэн талбай дээрээ аль болох л зах зээлийн сайн үнэлгээгээр үнэлэж борлуулаад тэрийгээ ямархуу байдлаар төлөвлөлтөө хийгээд, ямархуу байдлаар үр ашигтай хөрөнгө оруулалт хийхийг мэргэжлийн компаниудаар хийлгэхэд бас хугацаа орно. Мэдээлэл тодорхой болсон үед бол цаг аваад танилцаж болно. Мэдээж аль болох л үр ашигтай хийнэ.

С.Пүрэвжав:

- Компанийн засаглалийн хувьд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг гэдэг маш хэцүү хөндөгддөг эд. Ер нь нөлөө бүхий хэдэн хувьцаа эзэмшигчид л бүх асуудлыг шийддэг. Бид нар эсэргүүцсэн ч нээх айтхар нөлөө байхгүй.

Л.Гүндэгмаа:

- Хууль нь тийм.

С.Пүрэвжав:

- Харин тийм. Үүнийг бас засч залруулаад бас өөр болж байгаа. Хууль нь тийм гээд сууж болохгүй.

З.Номундарь:

- Нээлттэй оролцох юман дээрээ оролцоод тодорхой хэмжээнд саналаа хэлээд хамтарч ажиллаж бас болно.

Л.Гүндэгмаа:

- Олон Улсын жишигийн л хууль л даа.

С.Пүрэвжав:

- Үүн дээр олон Улсын кейс бас үүсчихсэн байгаа байхгүй юу. Зөвхөн танай компани худалдаж байгаа биш өөр бас нэг компани дээр ийм юм болоод өнгөрсөн жил тэрийг ч бас бид нар суугаад үзсэн. Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр ирж суухгүй байна гэдэг чинь бас бид нар дан ганц танай компанийн хувьцааг авч байгаа биш. Өмч хувьчлалаарч олгосон юм биш өөрсдийнхөө мөнгөөр худалдаад авсан юмныхаа хойноос өөрөө өөрийнхөө өмчийн хойноос эзэн болж явахгүй бол болохгүй болчихож байгаан. Хэлий цөөхөн ширхэг ч байсан мөнгөөрөө авсан эд. Хоёрхон хоногийн дотор л бүх компанийн хурлыг тавьж байна. өөр компанийх давхцаад л бүгд давхцаж байгаан.

Л.Гүндэгмаа:

- Гэхдээ бүгд ч бас биш ээ. Яг оролцъё гэвэл зав зай бас бий. Ядахдаа хуралд орно

гэвэл хэд хоногийн өмнө саналаа өгч болдог. Ямар асуудал хэлэлцэх нь сайт дээр тавьсан байдаг. Бүх зүйлээ үзээд ирээд саналаа өгч болно. Би ийм хуралтай болчихлоо уул нь би компанийнхаа хуралд оролцмоор байна, би ийм ийм санал тавья гээд саналаа тавьж болно тэр бол чөлөөтэй. Ер нь бол хичнээн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг гэж байгаа боловч хуулиараа нөлөөлнөө л гэж бодож байгаа бол ахиухан хувьцаа л нэмж авах хэрэгтэй. Тэгж байж л тэр хүний саналын эрх нэмэгддэг хуультай. Манай Монгол өөрөө тусдаа хуультай биш дэлхийн жишгээрээ хувьцаат компаниуд ерөнхийдөө хувьцаа эзэмшигчдийн тоогоор ширхэгээр шийддэг зарчимтай. Хэрвээ манайх хурлаа хийхгүй явбал жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг гэж бий. Манайх санхүүгийн зохицуулах хорооноос шууд гомдолоо гаргаж болно. Тэр нь чөлөөтэй байдаг. Энэ компани хурлаа хийхгүй байна, ногдол ашиг өгөхгүй байна, гээд.

С.Пүрэвжав:

- Хороо ч бас ажил хийдэггүй л газар л даа. Яваад үзсэн бас.

Л.Гүндэгмаа:

- Нэгэнт манай санхүүгийн зах зээлийг үндэслээд эрхийг нь бариад ажиллаж байгаагийн хувьд бол тэд нар бас олон хянан байцаагчтай. Манай дээр зөндөө л асуудлууд ирдэг. Янз бүрийн шаардлага, торгож байсан асуудал ч байдаг. Одоо ч бүх юм нээлттэй болсон сайтаар ороод үзэхэд хүртэл тэр компанид тэр тэр асуудлаас болж тийм шийдвэр гаргалаа гээд зөндөө л мэдээллүүд байдаг. Манайх ер нь анх хувьчлал явуулахдаа ард түмэндээ хувьчлалын мөн чанарыг ойлгуулаагүйгээс болоод ихэнхи нь цэнхэр ягаан тасалбараа зарим нь бараг ах дүүдээ зүгээр өгөөд тэрийг нь тодорхой хэмжээний мэдлэгтэй хүмүүс нь том том компаниа авсан. Гэхдээ сүүлийн үед манай залуучууд хувьцааны үр ашгийг ойлгоод өнөөдөр бас 2 хүн нэмээд ирсэн нь бас сонин л байна. Манайх бас зах зээл хэцүү л болж байна цаашид улам л хэцүү болох шинжтэй. Цаашид ингээд карго буулгаад л байгаад байх уу яах уу гээд. Тэрнээс өөр зүйл хийж чадахгүй яг л байдгаараа тэрнээс олсон хэдэн төгрөгөөрөө хэдэн ажилчидаа цалинжуулаад л зардалаа төлөөд, газрын төлбөр хамгийн их ачаатай байдаг. Бид нар газраа алдахгүйн тулд цалингаа хойшлуулж байгаад газрын төлбөрөө төлдөг.

С.Пүрэвжав:

- Газрын хувьд бол супер газар.

Л.Гүндэгмаа:

- Тийм, тийм

С.Пүрэвжав:

- Тойроод л орон сууцчихсан.

Л.Гүндэгмаа:

- 2013 онд танай энэ урд газар дээр барилга барих боломжгүй ээ танайхаас хаслаа гээд хассан. Доогуур нь ус сувгийн 2 том шугам явдаг. За нэгэнт тийм бол гээд хасуулсан. Жилийн дараа 2 шийдвэр хэдхэн хоногийн зайтай гараад өгчихсөн. Бид нар жил гаран шүүхдсэн. Дээд шүүх дээр хүртэл очиж байж газраа буцааж авсан.

Шүүхдэхэд их зардал гарсан. Саяхан хүртэл асуудал бас яригдаад л байсан. Одоо энэ том машинууд бас зогсоод бид хэд дийлэхгүй л байгаа.

С.Пүрэвжав:

- Тэнд байсан объект оо буулгасан тэ? Бүжиг явдаг байсан.

Л.Гүндэгмаа:

- Тэрийг өөр зориулалтаар засвар хийж байгаа. Түрээслэгч нь өөрөө засвар хийж байгаа.

Б.Мөнгэрэл:

- Тооллогын комиссын дарга Мөнгэрэл байна. Саналын тоог бид нар тоолоод гаргалаа. Ирсэн хүмүүсийн хувьцааны тоо нь 2,214,383 ширхэг хувьцаа байна. ирцээр харах юм бол 83,52% тай байна. Зөвшөөрсөн саналын хувьцаа нь 2,213,672 буюу 99,9% тай, татгалзсан саналын хувьцааны тоо 710 ширхэг, түдгэлзсэн саналын тоо нь 1 ш байна. иймээс өнөөдрийн хурлын хэлэлцсэн асуудал батлагдаж байна.

Л.Гүндэгмаа:

- За ингээд шийдвэрээ гаргаад дуусгая. Хурал дууслаа хүрэлцэн ирсэнд баярлалаа.

Хурал 15 цаг 10 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



Л.ГҮНДЭГМАА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



З.ТУУЛ